

ЗЭЭЛИЙН ДУГААР (ОУСБХБ) _____ МН

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

хоорондын

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(Тогтвортой эрчим хүчний шилжилтийг түргэсгэх зорилго бүхий

Олон шатлалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих

Эрчим хүч 4 төсөл)



Official Use Only

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хэлэлцээрийг Монгол Улс (цаашид "Зээлдэгч" гэх) болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (цаашид "Банк" гэх) хооронд хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр байгуулав. Зээлдэгч болон Банк хооронд дараах нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

ЗҮЙЛ I - ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁО

1.01. Ерөнхий нөхцөл нь (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсны дагуу) энэхүү Хэлэлцээрт хамаарах ба түүний салшгүй нэг хэсэг мөн.

1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол энэхүү Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёог Ерөнхий нөхцөл, Санхүүжилтийн гэрээ, эсхүл энэхүү Хэлэлцээр (түүний Удиртгал болон Хавсралтууд мөн хамаарна)-т тодорхойлсон утгаар ойлгоно.

ЗҮЙЛ II - ЗЭЭЛ

2.01. Банк нь Зээлдэгчид Төслийг санхүүжүүлэх зорилгоор далан найман сая (78,000,000 ам.доллар) америк доллартой тэнцэх хэмжээний зээл (цаашид "Зээл" гэх) олгохыг зөвшөөрсөн. Уг үнийн дүн нь валютын хөрвүүлэлтээс шалтгаалан өөрчлөгдөж болно.

2.02. Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг III-т заасны дагуу Зээлийн хөрөнгийг татан авч болно.

2.03. Үйлчилгээний хураамж нь зээлийн үнийн дүнгийн тэг зууны хорин тав (0.25%) хувьтай тэнцүү байна.

2.04. Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдлээс тооцогдох хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж нь жилийн тэг зууны хорин тав (0.25%) байна.


2.05. Зээлийн хүүгийн хэмжээ нь Жишиг хүү дээр Хувьсах хүүгийн нэмэгдлийг нэмсэнтэй тэнцүү, эсхүл Хөрвүүлсэн хувь хэмжээ байх бөгөөд энэ нь Ерөнхий нөхцөлийн 3.02(e) хэсэгтэй нийцсэн байна.

2.06. Зээлийн төлбөр гүйцэтгэх өдөр нь жил бүрийн 06 дугаар сарын 15 болон 12 дугаар сарын 15-ны өдөр байна.

2.07. Зээлийн үндсэн төлбөрийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасны дагуу эргэн төлнө.

ЗҮЙЛ III - ТӨСӨЛ

3.01. Зээлдэгч нь Төслийн болон ОШХ-ийн зорилтыг хангах үүрэг хүлээснээ үүгээр мэдэгдэж байна. Үүнтэй холбогдуулан Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн Зүйл V заалтууд



Official Use Only

болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т заасны дагуу Төслийг Эрчим хүчний яам (ЭХЯ)-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

ЗҮЙЛ IV - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

4.01. Хэлэлцээр хүчин төгөлдөр болоход дараах Нэмэлт нөхцөлийг хангасан байна. Үүнд:

(а) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Банкны хүлээн зөвшөөрсөн хэлбэр, агуулга бүхий Төслийн үйл ажиллагааны гарын авлага боловсруулан батална; мөн

(б) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцэд Төсөл удирдах багийг Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц бүрэлдэхүүн, хүний нөөц болон чиг үүргийн тодорхойлолттойгоор байгуулсан байна.

4.02. Хэлэлцээр хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш нэг зуун наян (180) хоногийн дотор байна.

4.03. Ерөнхий нөхцөлийн 9.05(б) хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн хүлээх үүрэг (төлбөрийн үүргээс бусад) дуусах өдөр нь Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш хорь (20) жил байна.

ЗҮЙЛ V - ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ; ХАЯГ

5.01. Зээлдэгчийн төлөөлөгч нь тухайн үеийн санхүүгийн асуудал эрхэлсэн Сайд байна.

5.02. Ерөнхий нөхцөлийн 10.01 хэсэгт заасан зорилгоор:

(а) Зээлдэгчийн хаяг:

Сангийн яам
Засгийн газрын II байр
С.Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар хот, 15160
Монгол Улс; ба


(б) Зээлдэгчийн цахим хаяг:

Факсын дугаар:
976-11-3202472

5.03. Ерөнхий нөхцөлийн 10.01 хэсэгт заасан зорилгоор:

(а) Банкны хаяг:

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк



болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т заасны дагуу Төслийг Эрчим хүчний яам (ЭХЯ)-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

ЗҮЙЛ IV - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

4.01. Хэлэлцээр хүчин төгөлдөр болоход дараах Нэмэлт нөхцөлийг хангасан байна. Үүнд:

(а) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Банкны хүлээн зөвшөөрсөн хэлбэр, агуулга бүхий Төслийн үйл ажиллагааны гарын авлага боловсруулан батална; мөн

(б) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцэд Төсөл удирдах багийг Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц бүрэлдэхүүн, хүний нөөц болон чиг үүргийн тодорхойлолттойгоор байгуулсан байна.

4.02. Хэлэлцээр хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш нэг зуун наян (180) хоногийн дотор байна.

4.03. Ерөнхий нөхцөлийн 9.05(б) хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн хүлээх үүрэг (төлбөрийн үүргээс бусад) дуусах өдөр нь Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш хорь (20) жил байна.

ЗҮЙЛ V - ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ; ХАЯГ

5.01. Зээлдэгчийн төлөөлөгч нь тухайн үеийн санхүүгийн асуудал эрхэлсэн Сайд байна.

5.02. Ерөнхий нөхцөлийн 10.01 хэсэгт заасан зорилгоор:

(а) Зээлдэгчийн хаяг:

Сангийн яам
Засгийн газрын II байр
С.Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар хот, 15160
Монгол Улс; ба


(б) Зээлдэгчийн цахим хаяг:

Факсын дугаар:
976-11-3202472

5.03. Ерөнхий нөхцөлийн 10.01 хэсэгт заасан зорилгоор:

(а) Банкны хаяг:

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк



1818 Н гудамж, Хойд, баруун хэсэг
Вашингтон хот, Колумбын тойрог 20433
Америкийн Нэгдсэн Улс; ба

(б) Банкны цахим хаяг:

Телекс:
248423(MCI) эсвэл 64145(MCI)

Факс: 1-202-477-6391

Хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____


ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____



Official Use Only

ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилт нь төсөл хэрэгжүүлэх орон нутгийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбох цахилгаан дамжуулах шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүний найдвартай байдлыг сайжруулахад оршино.


Төсөл нь ОШХ-ийн нэг үе шат бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Хэсэг 1. Цахилгаан дамжуулах шугамын барилгын ажил, холбогдох дэд станцын өргөтгөл

- (a) Барилга угсралтын ажил: (i) одоо байгаа Мандал дэд станцаас шинээр барих Өвөрхангай дэд станц хүртэлх 220 кВ хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам; (ii) шинэ Өвөрхангай дэд станц; мөн (iii) шинэ Өвөрхангай дэд станцыг одоо байгаа Арвайхээр – Баянхонгорын 110 кВ-ын дэд бүтцэд холбох шугам.
- (b) Өргөтгөлийн ажил: (i) одоо байгаа Мандал дэд станцыг 220 кВ хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамд холбох; мөн (ii) одоо байгаа Арвайхээр, Баянхонгор дэд станцуудыг өргөтгөх.

Хэсэг 2. Төсөл хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлэх

Дараах техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (a) ЭХЯ болон холбогдох агентлагуудын институцын болон техникийн чадавхыг бэхжүүлэх; (б) Төслийн хэрэгжилт болон удирдлагад дэмжлэг үзүүлэх, үүнд: санхүүгийн удирдлага, зарцуулалт, худалдан авалт, байгаль орчин болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн удирдлага, хяналт, тайлагнал, үнэлгээ багтана.



Official Use Only

ХУВААРЬ 2

Төслийн хэрэгжилт

Хэсэг I. Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалт

A. Институцын зохион байгуулалт

1. Зээлдэгч нь Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасны дагуу төсөл хэрэгжүүлэх хугацаанд улс, орон нутгийн түвшинд Банкны шаардлагад нийцсэн бүтэц, чиг үүрэг, орон тоо, нөөц бүхий Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтэц байгуулан ажиллуулна.
2. Дээр дурдсанаар хязгаарлагдахгүй Зээлдэгч нь дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш [нэг] сарын дотор СЯ, ЭХЯ, төсөл хэрэгжүүлэх орон нутгийн захиргааны төлөөллөөс бүрдсэн, ЭХЯ даргалсан Төслийн удирдах хороог байгуулна. Уг хороо Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох агентлаг хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах үүрэг хүлээнэ;


(б) Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн дэргэд байгуулах Төсөл удирдах баг нь доорх үүрэг хүлээнэ. Үүнд: (i) Төслийн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв (ЖАТТ) болон бусад тогтмол тайлан бэлтгэх; (ii) худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага, зарцуулалт, санхүүжилт, байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн менежмент, түүний дотор гомдол барагдуулах механизм хэрэгжүүлэх; (iii) Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг Төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцах.

Б. Төслийн үйл ажиллагааны гарын авлага

Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан зохион байгуулалт, дэг журмын дагуу (хэрэв энэхүү Хэлэлцээр болон Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан зохион байгуулалт, дэг журмын заалтууд хооронд ямарваа зөрчил үүсвэл энэхүү Хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө) Төслийг хэрэгжүүлэх ба Банк урьдчилан бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд Төслийн үйл ажиллагааны гарын авлагын аливаа заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, татгалзах эсхүл түдгэлзүүлэхийг хориглоно.

В. Төслийн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв

1. Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан төсөл хэрэгжүүлэх хугацаанд энэхүү Хуваарийн Хэсэг Д-д заасны дагуу хэрэгжүүлж буй эсхүл төлөвлөж буй байгаль орчин, нийгмийн арга хэмжээ, бүх зарлагын санхүүжилтийн эх үүсвэр зэрэг ирэх санхүүгийн жилд санал болгож буй төслийн бүх үйл ажиллагаа, зарлагыг агуулсан нэгтгэсэн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв (ЖАТТ)-ийг бэлтгэн 2026 оны санхүүгийн жилд багтаан Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш жар (60) хоногийн дотор, түүний дараагийн төсөл



Official Use Only

хэрэгжилтийн хугацаанд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор (эсхүл Банкны зөвшөөрсөн хугацаанд) Банкны зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.

2. Зээлдэгч нь Банкны хүлээн зөвшөөрсөн ЖАТТ-ийн дагуу тухайн төсвийн жилд Төслийг хэрэгжүүлнэ. Хэрэв төслийн ЖАТТ болон энэхүү Хэлэлцээрийн заалт хооронд зөрчил үүсвэл энэхүү Хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө.

3. Зээлдэгч нь Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Төслийн ЖАТТ-т ямарваа нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл оруулахыг зөвшөөрөхийг хориглоно.

Г. Зээлдэгч талын санхүүжилт.

Ерөнхий нөхцөлийн 5.03 дахь (Санхүүжилт болон бусад эх үүсвэрээр хангах) хэсгийн ерөнхий агуулгад хязгаарлалт тогтоохгүйгээр, Зээлдэгч нь Төслийн хэрэгжилтийн бүхий л хугацаанд дараах үүргийг хүлээнэ:

(1) 2(б) хэсэг (“Зээлдэгч талын санхүүжилт”)-ийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаанд зориулсан өөрийн санхүүжилтийг хангах зорилгоор Банкны зүгээс хангалттай хэмээн тооцогдох хэмжээний санхүүжилтийн хөрөнгийг цаг тухайд нь бүрэн хангаж эсхүл хангуулна;

(2) дээрх 1 дэх хэсэгт заасны дагуу шаардагдах Зээлдэгч талын санхүүжилтийн оролцооны төлөв байдлын талаар жил бүр, дор хаяж нэг удаа тайлан гаргаж, холбогдох баримт бичгийн хамт Банканд ирүүлнэ;

(3) Зээлдэгч талын санхүүжилтээр хэрэгжүүлэх бүх Төслийн үйл ажиллагаа нь энэхүү Хэлэлцээрийн дагуу хамаарах бүх шаардлага, түүний дотор Төслийн үйл ажиллагааны гарын авлагад заасан заалтуудыг бүрэн мөрдөж, хэрэгжилтийг хангана.

Д. Байгаль орчин, нийгмийн стандарт

1. Зээлдэгч нь Байгаль орчин, нийгмийн стандартад нийцүүлэн, Банкны хүлээн зөвшөөрөхүйц байдлаар Төслийг хэрэгжүүлнэ.

2. Зээлдэгч нь дээрх 1 дэх зүйлд зааснаар хязгаарлахгүй Банк хүлээн зөвшөөрөхүйц байдлаар Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (“БОНХТ”)-ний дагуу Төслийг хэрэгжүүлнэ. Үүний тулд Зээлдэгч дараах арга хэмжээг авна:

(а) БОНХТ-ний дагуу уг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ, үйл ажиллагааг урьдчилан шалгаж, үр дүнтэй хэрэгжүүлэх;

(б) БОНХТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг гаргах;

(в) БОНХТ-нд заасны дагуу түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлого, журмыг сахин мөрдөх, мэргэжлийн шаардлага хангасан, туршлагатай ажилтныг зохистой тоогоор авч ажиллуулах;

МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ТАА
АЛБАН ЕСНЭГ ОРЧУУЛГ А МӨН

Гарын үсэг /Signature/ А
20... 26 оны 03 сарын 09 өдөр
“Наанбаатар хот”

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Official Use Only

(г) БОНХТ-ний дагуу Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд БОНХТ эсхүл түүний аливаа заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, түдгэлзэх эсхүл татгалзахыг хориглох ба шинэчилсэн БОНХТ-г олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэх.

3. БОНХТ болон энэхүү Хэлэлцээрийн заалт хооронд аливаа зөрчил үүсвэл энэхүү Хэлэлцээрийн заалтыг мөрдөнө.

4. Зээлдэгч дараах арга хэмжээг авна.

(а) БОНХТ-нд заасан давтамжийн дагуу тогтмол тайлан эсхүл Банкны хүсэлтийн дагуу БОНХТ болон байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийг мөрдөж байгаа талаарх тусгайлсан тайлан цуглуулах, бэлтгэх, нэгтгэх, Банканд хүргүүлэх шаардлагатай бүх арга хэмжээ авах. Дараах мэдээллийг тусган Банкны хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр, агуулгаар бүх тайланг бэлтгэнэ. Үүнд: (i) БОНХТ-ний хэрэгжилтийн явц, (ii) БОНХТ хэрэгжүүлэхэд саад учруулах эсхүл саад учруулж болзошгүй аливаа нөхцөл байдал; (iii) ийм нөхцөл байдлыг арилгах эсхүл урьдчилан сэргийлэхээр авсан эсхүл авах шаардлагатай арга хэмжээ;

(б) БОНХТ, түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн хамгааллын арга хэрэгсэл, Байгаль орчин, нийгмийн стандартын дагуу байгаль орчин, орон нутгийн иргэд, төрийн албаны болон бусад ажилтнуудад ихээхэн сөрөг нөлөө үзүүлэхүйц эсхүл үзүүлсэн Төслийн үйл ажиллагаатай холбоотой эсхүл түүнд нөлөө үзүүлж буй тохиолдол эсхүл ослын талаар Банканд нэн даруй мэдэгдэнэ.


5. Зээлдэгч нь Төслийн нөлөөлөлд орсон хүмүүсийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, барагдуулахад дэмжлэг үзүүлэх гомдол барагдуулах хүртээмжтэй механизмыг боловсруулах, сурталчлах, ажиллуулах ба Банкны хүлээн зөвшөөрөхүйц байдлаар аливаа гомдлыг шийдвэрлэх эсхүл шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авна.

6. Зээлдэгч нь Төслийн хүрээнд хэрэгжүүлэх барилгын ажлын бүх тендерийн баримт бичиг болон гэрээнд гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, хяналт тавих этгээдийн хүлээсэн үүргийн талаар дараах заалтыг тусгасан байна. Үүнд: (а) БОНХТ болон түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн арга хэрэгслийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах; (б) байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжүүлэх барилгын ажил гүйцэтгэх явцад байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүүхдийн эсрэг хүчирхийллийг шийдвэрлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан ёс зүйн дүрмийг батлах, уг дүрмийг бүх ажилтанд хүргэж тэднээр гарын үсэг зуруулан, мөрдөн ажиллах.

Хэсэг II. Төслийн хяналт шалгалт, тайлагнал, үнэлгээ

А. Төслийн тайлан

Зээлдэгч нь тайлант улирлын Төслийн тайланг нэгтгэн тайлант улирал дуусгавар болсноос хойш (1) сарын дотор Банканд ирүүлнэ.



Official Use Only

Б. Дунд хугацааны хяналт

Зээлдэгч нь (а) Төсөл хүчин төгөлдөр болсноос хойш хорин дөрөв (24) сарын дараа Банкны хүссэн мэдээлэл бүхий Төслийн дунд хугацааны тайланг бэлтгэн Банканд хүргүүлнэ. Тайланд энэхүү А хэсгийн дагуу хэрэгжүүлсэн хяналт шалгалт, үнэлгээний арга хэмжээг харгалзан тайлант хугацаанд Төслийн гаргасан ололт амжилт, Төслийн зорилтыг хангах, үр дүнтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төлөвлөсөн арга хэмжээг тусгана; (б) Төслийн дунд хугацааны тайланг хүргүүлсэн өдөр болон түүнээс хойш дөчин тав (45) хоногт багтаан Банктай хамтран Төслийн дунд хугацааны тайланг хянах, тайлангийн дүгнэлт, зөвлөмж, энэ талаарх Банкны дүгнэлтэд үндэслэн Төслийн зорилтыг хангах, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэсэг III. Зээлийн хөрөнгийн татан авалт

А. Ерөнхий зүйл


Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн II зүйлээр хязгаарлагдахгүйгээр Зарцуулалт ба Санхүүгийн мэдээллийн албан захидлын дагуу зээлийн хөрөнгийг хуваарилсан хэмжээгээр болон хэрэв боломжтой бол доорх хүснэгтийн Зардлын зүйл анги тус бүрээр заасан хувь хэмжээгээр татан авалт хийж болно.

Зардлын зүйл анги	Хуваарилсан зээлийн үнийн дүн (ам.доллараар)	Санхүүжүүлэх зардлын хувь хэмжээ (үүнд гааль болон НӨАТ-аас бусад татвар багтсан)
(1) Бараа, ажил, зөвлөхийн бус болон зөвлөхийн үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, төслийн сургалт.	78,000,000	ОУСБХБ-ны хувь болох 100%-г, Төслийн ЖАТТ-ийн дагуу
Нийт	78,000,000	

Б. Санхүүжилт татан авах нөхцөл; татан авах хугацаа.

1. Дээрх А хэсгийн заалтыг үл харгалзан, хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн аливаа төлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар зээлийн хөрөнгийг татан авахгүй.


2. Татан авалт хийх сүүлийн хугацаа нь 2030 оны 12-р сарын 31-ний өдөр байна.



Official Use Only

Хэсэг IV. Бусад үүрэг хариуцлага

- А. Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх зорилгоор зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн аливаа бараа, ажил болон/эсвэл үйлчилгээний импорт, худалдан авалт болон/эсвэл нийлүүлэлт нь НӨАТ болон гаалийн татвараас (НӨАТ болон бусад) чөлөөлөгдөх нөхцөлөөр хангана.



Official Use Only

ХУВААРЬ 3

Амлалттай холбоотой эргэн төлөх хуваарь

Зээлдэгч нь Зээлийн үндсэн төлбөрийг дараах хүснэгтэд заасан хуваарийн дагуу төлнө. Уг хүснэгтэд зээлийн үндсэн төлбөрийг төлөх огноо болон тухайн огноонд зээлийн үнийн дүнгээс төлөгдөх үндсэн төлбөрийн хувийг (“Хэсэгчлэн төлөх хувь хэмжээ” гэх) тусгасан байна.

Зээлийн үндсэн төлбөр төлөх хугацаа	Хэсэгчилсэн төлбөрийн хувь хэмжээ (%)
12/15/2030	1.0300
6/15/2031	1.0600
12/15/2031	1.0800
6/15/2032	1.1100
12/15/2032	1.1400
6/15/2033	1.1700
12/15/2033	1.1900
6/15/2034	1.2200
12/15/2034	1.2600
6/15/2035	1.2900
12/15/2035	1.3200
6/15/2036	1.3500
12/15/2036	1.3900
6/15/2037	1.4200
12/15/2037	1.4600
6/15/2038	1.4900
12/15/2038	1.5300
6/15/2039	1.5700
12/15/2039	1.6100
6/15/2040	1.6500
12/15/2040	1.6900
6/15/2041	1.7300
12/15/2041	1.7700
6/15/2042	1.8200
12/15/2042	1.8600
6/15/2043	1.9100
12/15/2043	1.9600
6/15/2044	2.0100


МОНГОЛ УЛСЫН Сангийн яам
САН ЁСНЫ ОРЧУУЛГА МОН

... үсэр /Signature/ А
2026 оны 03 сарын 09 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Official Use Only

12/15/2044	2.0600
6/15/2045	2.1100
12/15/2045	2.1600
6/15/2046	2.2200
12/15/2046	2.2700
6/15/2047	2.3300
12/15/2047	2.3900
6/15/2048	2.4500
12/15/2048	2.5100
6/15/2049	2.5700
12/15/2049	2.6300
6/15/2050	2.7000
12/15/2050	2.7700
6/15/2051	2.8400
12/15/2051	2.9100
6/15/2052	2.9800
12/15/2052	3.0500
6/15/2053	3.1300
12/15/2053	3.2100
6/15/2054	3.2900
12/15/2054	3.3700
6/15/2055	2.9600



Official Use Only

Хэсэг I. Нэр томьёны тодорхойлолт

1. “Жилийн ажлын төлөвлөгөө ба төсөв” буюу “ЖАТТ” гэсэн товчлол нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.B-д дурдсан төлөвлөгөө, төсвийг хэлэх бөгөөд Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр төлөвлөгөөнд тухай бүр өөрчлөлт оруулж болно.
2. “Авлигатай тэмцэх удирдамж” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 6 дах хэсэгт заасан зорилгын үүднээс 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдөр батлан, 2011 оны 1 дүгээр сард шинэчилсэн 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаарх “ОУСБХБ-ны зээл, ОУХА-ын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийн санхүүжилттэй төслүүдийг залилан, авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай заавар” болно.
3. “Арвайхээр дэд станц” гэж Зээлдэгчийн Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд байрлах мөн нэртэй дэд станц болно.
4. “Баянхонгор дэд станц” гэж Баянхонгор аймгийн Баянхонгор суманд байрлах дэд станц болно.
5. “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” гэдэг нь Эрчим хүчний яамны дэргэд байгуулагдсан, эсхүл байгуулагдах “нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг хэлнэ. Уг нэгж нь 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн Засгийн газрын 24 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан (эсхүл байгуулагдана).
6. “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө” буюу “БОНХТ” гэж Төслийн 2025 оны 4 дүгээр сард хийгдсэн байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө бөгөөд энэхүү Хэлэлцээрт заасны дагуу Төслийн үзүүлэх байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг арилгахад чиглэсэн арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, зохион байгуулалт, хүний нөөц, сургалт, хяналт, тайлангийн зохицуулалт, тэдгээрийн дагуу боловсруулж хэрэгжүүлэх байгаль орчин, нийгмийн аливаа арга хэрэгслийг агуулсан Зээлдэгчийн зүгээс хэрэгжүүлэх шаардлагатай эсхүл хэрэгжүүлэхэд хүрсэн материаллаг арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхойлсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр оруулж болно.
7. “Байгаль орчин, нийгмийн стандарт” буюу “БОНС” гэж Банкнаас нийтэлсэн бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон дараах стандартыг нийтэд нь хэлнэ: (i) “Байгаль орчин, нийгмийн стандарт 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, менежмент”; (ii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 2: ажиллах хүчин ба хөдөлмөрийн нөхцөл”; (iii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 3: Нөөцийг зохистой ашиглах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, удирдах”; (iv) “Байгаль орчин, нийгмийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал”; (v) “Байгаль орчин, нийгмийн стандарт 5: Газар чөлөөлөх, газар ашиглахыг хязгаарлах, албадан нүүлгэн шилжүүлэх”; (vi) “Байгаль орчин, нийгмийн стандарт 6: Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент”; (vii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 7: Уугуул иргэд/ Африкийн Сахарын бүсийн нутгийн уугуул иргэд”;

Үсэг /Signature/ А


2026 оны 03 сарын 09 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Official Use Only

(viii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 8: Соёлын өв”; (ix) “Байгаль орчин, нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучлагч”; (x) “Байгаль орчин, нийгмийн стандарт 10: Оролцогч талуудын оролцоо ба мэдээллийн ил тод байдал”.


8. “Ерөнхий нөхцөл” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн (2023 оны 7 дугаар сарын 15-ны өдөр сүүлийн байдлаар шинэчлэн найруулсан) Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны “ОУСБХБ-ны санхүүжилт, хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн ерөнхий нөхцөл”-ийг хэлнэ.
9. “кВ” гэж цахилгааны хүчдэл хэмжих стандарт хэмжүүр болох киловольт буюу нэг мянган (1,000) вольт болно.
10. “Мандал дэд станц” гэж Дундговь аймгийн Сайнцагаан суманд байрлах мөн нэртэй дэд станцыг хэлнэ.
11. “ЭХЯ” гэж Зээлдэгчийн Эрчим хүчний яам, эсхүл түүний хууль ёсны залгамжлагчийг хэлнэ.
12. “СЯ” гэж Зээлдэгчийн Сангийн яам, эсхүл түүний хууль ёсны залгамжлагчийг хэлнэ.
13. “Олон шатлалт хөтөлбөр буюу ОШХ” гэж Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн цахилгаан, дулааны дэд салбарт сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрчим хүчний шилжилтийг дэмжихэд чиглэсэн олон шатлалт хөтөлбөрийг хэлнэ.
14. “Үйл ажиллагааны зардал” гэж төслийн өдөр тутмын уялдаа холбоо бүхий удирдлага, зохион байгуулалт, хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, зөвлөхийн бус үйлчилгээний зохистой зардлыг хэлнэ. Үүнд тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байгууламж, албан тасалгааны түрээс болон хэвийн засвар үйлчилгээ, түлш, оффисын хэрэгсэл, ашиглалтын төлбөр, хэрэглээний зүйлс, харилцаа холбооны зардал (шуудан, утас, интернет), тээвэр, орчуулга, хэвлэх, хуулбарлах, банкны шимтгэл, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, даатгал, төсөлтэй холбоотой уулзалт, төсөлтэй холбоотой аялал, амьдрах болон байрлах зардал, гэрээт дэмжлэгийн ажилтан болон төсөлтэй шууд холбоотой бусад удирдлагын зардлууд орно. Гэхдээ зээлдэгчийн төрийн албан хаагчдын цалин, урамшуулал, шимтгэл, шагнал, түүнтэй адилтгах төлбөрийг оруулахгүй.
15. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 85 дах зүйлийг хэрэгжүүлэх үүднээс 2023 оны 9 дүгээр сард баталсан, 2025 оны 2 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан “Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт авч буй Зээлдэгчид зориулсан Дэлхийн Банкны худалдан авах ажиллагааны журам”-ыг хэлнэ.
16. “Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэр” гэж Зээлдэгчийн Баянхонгор, Өвөрхангай, Дундговь аймаг дах Мандалговь-Арвайхээр цахилгаан дамжуулах агаарын шугам



Official Use Only

дайран өнгөрдөг газар нутгийг, мөн Төсөл хэрэгжих явцад Банктай тохиролцон Зээлдэгчийн сонгосон бусад орон нутгийг нийтэд нь хэлнэ.

17. “Төсөл удирдах баг” гэж Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн дэргэд байгуулагдсан, энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.A.2.(б)-д заасны дагуу Зээлдэгчийн байгуулан ажиллуулах алба эсхүл түүний хууль ёсны залгамжлагч төсөл хэрэгжүүлэх багийг хэлнэ.
18. “Төслийн үйл ажиллагааны гарын авлага” гэж Зээлдэгчийн ЭХЯ-аар дамжуулан баталж, төслийн хэрэгжилтийн явцад шинэчлэх гарын авлагыг хэлнэ. Уг гарын авлагад дараах зохицуулалт, дэг журмын асуудлыг нарийвчлан тусгана. Үүнд: (а) институцын зохион байгуулалт, зохицуулалт, төслийн өдөр тутмын хэрэгжилт; (б) хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн удирдлага; (в) худалдан авах ажиллагаа; (г) байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн арга хэмжээ; (д) хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал, мэдээлэл харилцаа; (е) шударга байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө; (ж) олон улсын сайн туршлага, Төслийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагад нийцүүлэн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах; (ж) төсөлд шаардагдах бусад захиргааны, санхүүгийн, техникийн болон зохион байгуулалтын зохицуулалт, дэг журам. Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр уг гарын авлагад өөрчлөлт оруулж болох ба гарын авлагын хуваарьт уг нөхцөлийг тусгана.
19. “Төслийн удирдах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.A.2.(а)-д заасны дагуу Зээлдэгчийн байгуулан ажиллуулах хороо эсхүл түүний хууль ёсны залгамжлагч этгээдийг хэлнэ.
20. “Хэлэлцээрт гарын үсэг зурсан огноо” гэж Зээлдэгч болон Банк энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр огнооны сүүлийн огноог хэлэх бөгөөд уг тодорхойлолт нь энэхүү Хэлэлцээр болон Ерөнхий нөхцөлд дурдсан “Зээлийн хэлэлцээрийн огноо”-ны бүх ишлэлд хамаарна.
21. “Сургалт” гэж Банкнаас баталсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн Төслийн хүрээнд зохион байгуулж буй сургалт, семинар, туршлага судлах аялалд боловсон хүчнийг оролцуулахад шаардагдах бараа, үйлчилгээний үндэслэл бүхий зардлыг хэлнэ. Уг зардалд сургалт, семинар, танилцах аялалд оролцогчдын томилолтын зардал, сургагч багшийн үйлчилгээтэй холбоотой зардал, сургалт, семинарын байрны түрээсийн төлбөр, сургалт, семинарын материал бэлтгэх, олшруулах зардал, сургалт, семинар эсхүл танилцах аялалд бэлтгэх, зохион байгуулахтай холбоотой бусад зардлыг хамруулах ба харин зөвлөхийн цалин хөлс, Зээлдэгчийн төрийн албан хаагчийн цалин, урамшуулал, шан харамж, эсхүл түүнтэй адилтгах зардлыг хамруулахгүй.
22. “Өвөрхангай дэд станц” гэж нь зээлийн төслийн эх үүсвэрээс санхүүжигдсэн Өвөрхангай аймгийн Тарагт суманд байрлах ижил нэртэй дэд станц болно.



Official Use Only

Хэсэг II. Ерөнхий нөхцөлийн өөрчлөлтүүд

Ерөнхий нөхцөлд дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1. Хэсэг 3.01 (Үйлчилгээний хураамж; Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, Эрсдэлийн нэмэлт хураамж)- ийг дараах байдлаар шинэчлэн найруулав:

“Хэсэг 3.01. Үйлчилгээний хураамж, Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж

(а) Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрт заасан хувь хэмжээгээр “Үйлчилгээний хураамж”-ийг Банканд төлнө. Хэсэг 2.07(б)-д өөрөөр заагаагүй бол Зээлдэгч нь “Хүчин төгөлдөр болсон өдөр”-өөс хойш жар (60) хоногийн дотор уг Үйлчилгээний хураамжийг төлнө.


(б) Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрт заасан хувь хэмжээгээр татан аваагүй зээлийн хөрөнгийн үлдэгдэлд “Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж”-ийг Банканд төлнө. Уг зээлийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж нь Зээлийн хэлэлцээр байгуулсан өдөр эсхүл Зээлийг Банк баталсан өдрөөс хойш дөрөв дэх жилийн ойн өдрийн аль сүүлийн өдрөөс эхлэн тооцогдох бөгөөд Зээлдэгч нь Зээлийн данснаас зарцуулалт хийсэн эсхүл цуцалсан тухайн өдрүүд хүртэл хуримтлагдана. Зээлдэгч нь, Хэсэг 2.07 (в)-д өөрөөр заагаагүй бол, Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг хагас жил тутам Зээлийн төлбөр гүйцэтгэх өдөр төлнө.

2. Хэсэг 3.04 (Урьдчилсан төлбөр)-ийг дараах байдлаар шинэчлэн найруулав:

“3.04. Урьдчилсан төлбөр

(а) Зээлдэгч нь Банканд дөчин таваас доошгүй (45) хоногийн өмнө мэдэгдэл өгсний дараа Банкны хүлээн зөвшөөрсөн өдөр дараах дүнг хугацаанаас нь өмнө Банканд буцаан төлж болно (Зээлдэгч нь тухайн өдөр хүртэл төлбөл зохих бүх зээлийн төлбөрийг бүрэн төлсөн тохиолдолд): (i) тухайн өдрийн байдлаар татан авсан зээлийн үлдэгдлийг бүхэлд нь; эсхүл (ii) аль нэг буюу хэд хэдэн хуваарьт Зээлийн үндсэн дүнг бүхэлд нь. Татан авсан зээлийн үлдэгдлийг хэсэгчлэн урьдчилж төлөхдөө Зээлдэгчийн өөрийн заасан журмаар төлнө, эсхүл Зээлдэгч тодорхой журам заагаагүй бол дараах байдлаар төлнө: (А) хэрэв Зээлийн хэлэлцээрт Зээлийн үндсэн төлбөрийн тодорхой зарцуулсан дүнгүүдийг тусад нь хуваарилан төлөхөөр заасан бол хамгийн сүүлд татан авсан дүнг эхэлж төлөх зарчмаар, тухайн зарцуулсан дүнгийн хамгийн сүүлийн хугацаатай хэсгээс эхлэн урвуу дарааллаар хамааруулан төлнө; (Б) бусад бүх тохиолдолд урьдчилж буцаах төлбөрийг зээлийн хугацаа нь болсоноос эсрэг дарааллаар төлөх буюу хамгийн сүүлийн хуваарьт хугацааны дүнг эхэлж төлнө.

(б) Хэрэв хугацаанаас өмнө төлөхөөр төлөвлөж буй Зээлийн аливаа дүнтэй холбогдуулан Хөрвүүлэлт хийгдсэн бөгөөд тухайн үед Хөрвүүлэлтийн хугацаа дуусаагүй байвал, Хэсэг 4.06-д заасан заалтууд хамаарна.




Official Use Only

3. Дараах нэр томьёоны тодорхойлолтыг Хавсралтад цагаан толгойн үсгийн дарааллаар шинээр [#]-[#] догол мөрүүд болгон нэмэх бөгөөд, үүний улмаас бусад тодорхойлолт (хамааралтай бол) -ийг зохих ёсоор дахин дугаарлав.

“75. “Зээлийн төлбөр” гэж Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээлийн холбогдогч талуудын Банканд төлөх үүрэг хүлээсэн аливаа төлбөрийг ойлгох бөгөөд үүнд (гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй) Зээлдэгчээс төлөх татан авсан зээлийн үлдэгдэл, хүү, үйлчилгээний хураамж, хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, хугацаа хэтэрсний хүү (хэрэв байгаа бол), аливаа нэмэлт хураамж, хөрвүүлсний хураамж, хөрвүүлснийг хугацаанаас нь өмнө цуцалсны хураамж, зээлийн хүүгийн дээд хязгаар эсвэл зээлийн хүүгийн өөрчлөлтийн дээд, доод хязгаар тогтоосны урьдчилгаа шимтгэл, хаалтын төлбөрийг хэлнэ.

“81. “Зээлийн төлбөр гүйцэтгэх өдөр” гэж Зээлийн хэлэлцээрт заасны дагуу Зээлийн хэлэлцээр байгуулсан өдөр эсхүл түүнээс хойш тохиох, зээлийн хүү, зээл ашиглаагүй үлдэгдэлд ногдох хураамж болон бусад зээлийн төлбөр, шимтгэл (үйлчилгээний хураамжаас бусад)-ийг төлөх ёстой өдөр бүрийг ойлгоно.

4. Хавсралтын 4-т заасан (“Хуваарилсан илүү эрсдэлийн дүн”); 53-т заасан (“Эрсдэлийн нэмэлт хураамж”); 99-т заасан (“Стандарт эрсдэлийн хязгаар”) нэр томьёоны тодорхойлолт болон 105-д заасан (Нийт эрсдэл) нэр томьёоны тодорхойлолтыг бүхэлд нь хүчингүй болгож, дараагийн догол мөрүүдийг зохих ёсоор дахин дугаарлав.



Official Use Only